АМЬТНЫ АЙМАГ

Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэрт 300 гаруйн сээр нуруутан байгаагаас 4 баг, 13 овог, 45 зүйлийн хөхтөн бүртгэгдсэн ба нэн ховор 3 зүйл, ховор 7 зүйлийн хөхтөн байдаг. Үүнээс нэн ховор, олон улсын улаан номд бүртгэлтэй цоохор ирвэс, голын халиу: зэрлэг амьтан, ургамлын ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах конвенцын 1-р хавсралтад бүртгэлтэй цоохор ирвэс, голын халиу: 2-р хавсралтанд орсон шилүүс мий, мануул мий, Дархан цаазтай халиун буга, янгир ямаа, аргаль хонь, цоохор ирвэс, ойн булга, суусар булга зэрэг хөхтөн амьтан нутагладаг. Эдгээр амьтдын үндсэн байршил нутаг нь Хөх Сэрхийн дархан газар, Алтайн Таван Богдын БЦГ, Сийлхэмийн БЦГ, Цамбагаравын БЦГ, Дэвэлийн арлын БНГ юм. 11 зүйлийн хэвлэлээр явагч, 120 гаруй зүйлийн шувуу байгаагаас. “Монгол улсын ”, Азийн ”Улаан ном ”, зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах конвенц /CITES/-ийн нэг, хоёрдугаар хавсралт, нүүдэллэдэг зүйлүүдийг хамгаалах олон улсын конвенц /CMS/-ийн нэг, хоёрдугаар хавсралтанд бүртгэлтэй , Монгол Улсын Засгийн газрын тогтоол, тушаалаар хамгаалсан 31 зүйл шувуу Монгол Алтайн уулархаг гол нуруунд нутаглаж байна.

Монгол Алтайн уулархаг нутгийн Хотон, Хоргон, Даян, Толбо, зэрэг томоохон нуурууд, Ховд, Булган, Буянт, Ёлт, Хуримт гол болон бусад том жижиг голууд бор галуу, буурал галуу, ангир, зэрлэг нугас, ногоохон нугас, бор нугас, гэзэгт шумбуур, алаг шумбуур, дөрт нугас, хумхин нугас гэх 10 зүйл спорт агнуурын болон агнуурын өргөн ач холбогдол бүхий усны шувуутай. Эдгээр шувуу дээрх нэр бүхий нуур, голуудад үүрлэн өндөглөж, үр удмаа бойжуулан өсгөж хаваржиж, зусаач, намаржаад Монгол орны эрс тэс уур амьсгал, экологийн онцлог нөхцөлөөс шалтгаалж төрөлх нутгийнх нь идээшил гол, нуур хөлдөхөд аргагүйн эрхэнд дулаан орныг зорьж, тэнд өвөлжиж, хавар эргэж ирдэг.

Ямар нэгэн хэмжээгээр хамгаалсан 31 зүйл шувуудын 23% нь Монгол Улсын “Улаан ном”, 5 хувь нь Азийн “Улаан ном”-д бүртгэлтэй дээр Монгол Улсын хуулиар агнахыг хорьсон “Дархан цааз”-тай шувуу 11 хувийг эзэлж байна. Монгол Улсын “Улаан ном” болон ховор амьтны жагсаалтад хуруут хун, гангар хун, Алтайн хойлог, гургуул, хошуу галуу, хээрийн галуу, хар өрөвтас, загасчин явлаг, итэлгэн цахлай, релит цахлай гэх 10 зүйл, Азийн “Улаан ном”-д нохой тас, зээрд шонхор 2-ийг тус тус бүртгэж хамгаалсан юм.

Алтайн хойлгийг-1973 онд, Гургуулыг-1975 онд, Хээрийн галууг-1975 онд, Гангар хунг-1973 онд, Хуруут хунг-1973 онд Монгол Улсын хуулиар хамгаалан агнахыг хорьж, “Дархан цаазтай” болгосон билээ. Релит цахлай “Зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах конвенц”-ийн /CITES/ нэгдүгээр хавсралтад, үлэг харцгай, морин харцгай, ойн сар, шилийн сар, бахим бүргэд, тарважи, цармын бүргэд, оч ёл, нохой тас, сохор элээ, идлэг шонхор, хайргууна шонхор, зээрд шонхор, начин шонхор, хархираа тогоруу, өвөгт

тогоруу, итэлгэн цахлай, эгэл шар шувуу, соотон гуйванга, савагт ариан, хотны бүгээхэй мөн конвенцын / CITES/ 2 дугаар хавсралтад бүртгэлтэй байна.

Монгол Алтайн нурууны төв Азийн гадагч урсгалтай ай савд хамаарах Ховд, Буянт, Хуримт, Сонгионт, Булган зэрэг гол, Толбо, Хотон, Хурган, Даян зэрэг нууруудад Монгол хадран, Шивэр сугас, Шаргал үхэрдэй, Шивэр гүрц, Ердийн гүрц, Голын алгана гэх 10 зүйлийн идэштэн нутаглаж байна. Монгол хадран, Зарам, Улаан нүдэн, Алтайн сугас, Голын алгана зэрэг 6 зүйл буюу 60 хувийг агнуурын үндсэн, бусад нь спорт агнуурын юм уу ан авд өгөөш болгон хэрэглэдэг жижиг загаснууд /30 хувийг / эзэлнэ. Шаргал үхэрдэй бол Монгол улсын “Улан ном-д ” бүртгэлтэй, Манай орны зөвхөн Булган голд цөөн байдаг ховор загас, нийт зүйлийн 10 хувийг эзэлж байна.

АЙМГИЙН ЗАГАСНЫ НӨӨЦ

2017 онд ШУА-ийн ерөнхий ба сорилын биологийн хүрээлэн Баян-Өлгий аймгийн зарим нуурт загасны нөөцийг тогтоох судалгаа хийсэн. Ачит, Толбо, зэрэг нууруудаас загас агнаж эхэлжээ. Одоогийн байдлаар үйлдвэрлэлийн журмаар загас агнах зөвшөөрөл улсаас ирдэг боловч аймагт загас үйлдвэрлэлийн журмаар агнах эрх бүхий байгууллага 2019-2020 онуудад Толбо ,Ачит жил бүр загас агнаж байна.

№	Нуурын нэр	Нөөцийн тойм /тонн/	Жилд барих загасны хэмжээ /тонн/	Агнуурын үндсэн загас /%/
4	Ачит	123.5	12	Нохой болон шар сугас-70 % Монгол хадран-30%
5	Толбо	99.4	20	Нохой болон шар сугас-82,4% монгол хадран-17,6 %
Нийт		222.9	36	